



Их / дээд сургуульд сурах, дээд сургуульд орох хэлний бэлтгэлд сурах, дээд сургуульд элсэн орох өргөдөл гаргах (§16b AufenthG bzw. §17 AufenthG)

Ерөнхий зааварчилгаа

1. Доорх зааварчилгааг анхааралтай уншиж визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтаа бүрдүүлнэ үү.
2. Доорх жагсаалтын дагуу бичиг баримтаа эрэмбэлнэ үү. Тухайн баримт бичиг байгаа тохиолдолд өмнөх нүдийг чагтална үү.
3. Улаанбаатар дахь Германы Элчин сайдын яам нь **Монголд амьдарч байгаа эсвэл Монголд албан ёсоор оршин суух зөвшөөрөлтэй иргэний** визийн мэдүүлгийг хүлээн авах боломжтой.
4. **Үндэсний визийн мэдүүлгийг боловсруулах хугацаа хэдэн долоо хоногоос хэдэн сар хүртэл үргэжилж болно.** Зарим тохиолдолд Таны визийн мэдүүлгэнд Германы дотоодын байгууллагуудаас зөвшөөрөл авах шаардлагатай болдог. Визийн мэдүүлгийг боловсруулж дуусмагц Элчин сайдын яамнаас Тантай холбогдох болно. **Визтэй паспортаа Элчин садын яамнаас авахаас өмнө онгоцны тийзээ худалдаж авахгүй байхыг зөвлөж байна.**
5. Үндэсний визийн мэдүүлэхэд заавал өгөх [VIDEX](https://videx.diplo.de/videx/visum-erfassung/videx-langfristiger-aufenthalt) маягыг онлайн бөглөөд хэвлэж гаргана
<https://videx.diplo.de/videx/visum-erfassung/videx-langfristiger-aufenthalt>
6. Тус Элчин сайдын яам нь энэ төрлийн үндэсний визийн мэдүүлгийг хүлээн авах үйлчилгээг өөрийн түнш **VFS Global-д шилжүүлсэн** болно. Ямар нэгэн өөр зуучлагч этгээд, байгууллагаар дамжуулах шаардлагагүй гэдгийг ЭСЯ анхааруулж байна. Зуучлагч этгээд, байгууллагууд нь виз мэдүүлэх цаг авах онцгой эрх байхгүй, ялангуяа визийн мэдүүлгийн шийдвэрт нөлөөлөх боломж огтоос байхгүй. VFS Global төв онлайнар цаг олгодог. VFS Global визийн мэдүүлэг хүлээн авах төв мөн ямар нэгэн гуравдагч этгээд, байгууллагатай хамтран ажилладаггүй. Тус байгууллага нь визийн мэдүүлгэнд бэлдсэн бичиг баримтыг хүлээн авах ба таны биометр мэдээллийг мөн авна. Үүний дараа Таны визийн мэдүүлгийг Германы ЭСЯ-ны Визийн хэлтэс рүү шийдвэрлүүлэхээр илгээдэг.
7. Визийн мэдүүлгээ өгөх цагийг **Та шууд VFS Global-ын цаг олгох системээр дамжуулан тохирно үү.**
8. Визийн мэдүүлэгт зориулж бэлдсэн баримт бичгүүдийг **эх хувь** болон хуулбар мөн **герман эсвэл англи хэл дээрх орчуулгын хамт өгнө.**



9. Таны бүрдүүлсэн бичиг баримт **энэхүү жагсаалтын дагуу бүрэн гүйцэд** байж гэмээн хүлээн авах боломжтой гэдгийг анхаарна уу! Та бүрэн гүйцэд болоогүй визийн мэдүүлгээ заавал өгнө гэсэн байр суурьтай бол хүлээн авч болох хэдий ч энэ нь визийн мэдүүлгийг татгалзсан шийдвэрт хүргэж болзошгүй гэдгийг тооцоолох хэрэгтэй. Танд виз олгохын тулд зарим тохиолдолд Элчин сайдын яам нь нэмэлт бичиг баримт шаардах эрхтэй.
10. ЭСЯ–наас шаардаагүй бичиг баримт нэмж өгөх, цахим шуудангаар элдэв захидал илгээхгүй байхыг хүсч байна. Ялангуяа визийн мэдүүлгээ хараахан өгөөгүй бол урьдчилан ямар нэгэн бичиг баримт, цахим захидал ЭСЯ–руу илгээх шаардлагагүй. Ийм төрлийн бичиг баримтыг хадгалах боломжгүй. Та цаг тохирсон өдрөө визийн мэдүүлгэнд шаардлагатай бичиг баримтаа жагсаалтын дагуу бүрэн гүйцэд бүрдүүлж өгнө үү.
11. Визийн мэдүүлгийн талаарх үнэн зөв, бодит мэдээллийг Элчин сайдын яамны цахим хуудаснаас авч байхыг зөвлөж байна: [90-ээс дээш хоногоор оршин суух үндэсний виз - Auswärtiges Amt \(diplo.de\)](https://www.auswaertiges-amt.de/de/visum-erfassung/visum-langfristiger-aufenthalt)

Визийн мэдүүлэгт заавал өгөх бичиг баримт

Зааварчилгаа: Баримт бичиг бүрийг **эх хувь болон хуулбарын** хамт өгнө. Баримт бичгийн эх хувийг шалгаж дуусаад Танд эргүүлэн олгоно. Баримт бичгээс хуулбар хийхдээ А4 хэмжээтэй бичгийн цаасны зөвхөн **нэг тал дээр хувилах** (ар өвөргүй хувилж болохгүй) бөгөөд олон хуудас бүхий **баримт бичгийг нэгтгэн үдэх, наах хэрэггүй** салангид өгнө.

1. Гадаад паспорт

- Гадаад паспорт нь сүүлийн 10 жил дотор олгосон, багадаа 2 сул нүүртэй бөгөөд элдэв гэмтэлгүй байх ёстой.
- Гадаад паспорт нь визийн хугацаа дууссанаас хойш багадаа 3 сар илүү хүчинтэй байх ёстой.
- Гадаад паспорт нь эзэмшигчийн гарын үсэгтэй байх ёстой.
- Гадаад паспорт дээрх гэрэл зураг ба эзэмшигчийг харьцуулан харахад илт танигдахуйц байх ёстой.
- Гадаад паспорт эзэмшигчийн мэдээлэл бүхий нүүр, гарын үсэгтэй нүүр болон визийн наалт бүхий нүүрнээс хийсэн хуулбар.
- Урьд өмнө авч байсан гадаад паспорт байх аваас мөн визийн наалт бүхий нүүрнээс хийсэн хуулбар.

2. Виз мэдүүлэх маягт болон дагалдах танилцуулах хуудас

- Бүрэн гүйцэд бөглөсөн бөгөөд виз мэдүүлэгч өөрөө гарын үсгээ зурсан VIDEX–маягт болон дагалдах танилцуулга, зааварчилгааны хуудас
<https://videx.diplo.de/videx/visum-erfassung/videx-langfristiger-aufenthalt>

3. 2 хувь биометр шаардлагад нийцсэн цээж зураг (www.biometrisches-passbild.net)

- Цээж зураг нь сүүлийн 6 сар дотор авахуулсан байх ёстой
- Цээж зураг нь цайвар өнгийн дэвсгэртэй байх ёстой



<input type="checkbox"/> Цээж зурганд элдэв засвар өөрчлөлт хийхийг хориглоно
4. Оршин суух зөвшөөрөл
<input type="checkbox"/> Монгол Улсад суугаа гадаадын иргэн албан ёсоор оршин сууж буй зөвшөөрөл ба гадаад паспортын Монгол Улс руу нэвтрэн ороход дарсан штамп бүхий нүүрнээс хийсэн хуулбар
5. Насанд хүрээгүй виз мэдүүлэгч
<input type="checkbox"/> Визийн мэдүүлгийн маяганд асрамжлах эрх бүхий хүмүүс гарын үсэг зурна.
<input type="checkbox"/> Асрамжлах эрх бүхий хүмүүсийн нотариатаар баталгаажуулсан зөвшөөрөл нь сүүлийн 3 сар дотор гаргасан байх бөгөөд Герман руу визийн мэдүүлгийн зорилгын дагуу шилжин суурьших, удаан хугацаагаар оршин суухыг зөвшөөрч буй талаар тодорхой тусгасан байна.
<input type="checkbox"/> Төрсний гэрчилгээ хуулбар орчуулгын хамт
<input type="checkbox"/> Эцэг эхийн аль нэг нь нас барсан эсвэл асрамжлах эрхээ алдсан тохиолдолд: Нас барсан гэрчилгээ эсвэл асрамжлах эрх хэнд үлдэж хэн нь алдсан тухай шүүхийн шийдвэр.
<input type="checkbox"/> Асрамжлах эрх бүхий хүмүүсийн гадаад паспорт эсвэл иргэний үнэмлэхийн хуулбар
6. Оршин суух зорилгоос хамаарч бүрдүүлэх бичиг баримт – Их/Дээд сургууль/ Коллеж
<input type="checkbox"/> Их/Дээд сургуульд шууд сурах зөвшөөрөл(unbedingter Zulassungsbescheid) эсвэл
<input type="checkbox"/> Коллежид шууд сурах зөвшөөрөл (unbedingter Zulassungsbescheid eines Studienkollegs)
<input type="checkbox"/> Ерөнхий боловсролын гэрчилгээ , их дээд сургууль төгссөн бол диплом болон дүнгийн хавсралт
<input type="checkbox"/> Та одоогоор ажил эрхэлж байгаа бол ажлын газрын тодорхойлолт
<input type="checkbox"/> Das Deutsche Sprachdiplom (DSD) – Герман хэлний диплом эсвэл B2 ба түүнээс дээш түвшний герман хэлний ALTE (Association of Language Testers in Europe) стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байгууллагаас олгосон сертификат
<input type="checkbox"/> Германд дээд боловсрол эзэмших болсон шалтгаан, өөрийн сонгосон мэргэжлийн тухай, хэтийн зорилгын талаарх бичмэл тайлбар захидал (Motivationsschreiben) герман хэл дээрх орчуулгын хамт
<input type="checkbox"/> Өнөөг хүртэл эзэмшсэн боловсрол, мэргэжил болон эрхэлж байсан ажил, хөдөлмөрийн талаарх бүрэн гүйцэд бичсэн, хүснэгтчилсэн намтар герман хэл дээрх орчуулгын хамт
7. Оршин суух зорилгоос хамаарч бүрдүүлэх бичиг баримт – дээд сургуульд орох хэлний бэлтгэл
<input type="checkbox"/> дээд сургуульд элсэн ороход зориулсан хэлний курсэд бүртгүүлсэн бөгөөд курсын төлбөр төлсөн баримт. Хэлний курс нь долоо хоногт багадаа 18 цагийн хичээлийн цагтай байх ёстой
<input type="checkbox"/> Германы их/дээд сургуульд элсэн орох нөхцлийг хангасан тухай баримт
<input type="checkbox"/> байгаа бол: дээд сургуульд сурах болзолт зөвшөөрөл (bedingter Zulassungsbescheid)
<input type="checkbox"/> Ерөнхий боловсролын гэрчилгээ , их дээд сургууль төгссөн бол диплом болон дүнгийн хавсралт
<input type="checkbox"/> байгаа бол: Хэлний мэдлэгийг батлах баримт (Герман хэл: DSH эсвэл TestDaF шалгалтын дүн, Англи хэл: IELTS–Сертификат)
<input type="checkbox"/> Өнөөг хүртэл эзэмшсэн боловсрол, мэргэжил болон эрхэлж байсан ажил, хөдөлмөрийн талаарх бүрэн гүйцэд бичсэн, хүснэгтчилсэн намтар герман хэл дээрх орчуулгын хамт
<input type="checkbox"/> Та одоогоор ажил эрхэлж байгаа бол ажлын газрын тодорхойлолт



Германд дээд боловсрол эзэмших болсон шалтгаан, өөрийн сонгосон мэргэжлийн тухай, хэтийн зорилгын талаарх бичмэл тайлбар захидал (**Motivationsschreiben**) герман хэл дээрх орчуулгын хамт

8. Оршин суух зорилгоос хамаарч бүрдүүлэх бичиг баримт – дээд сургуульд элсэн орох өргөдөл гаргах

Их/дээд сургуулийн бүртгэлд орсон тухай баримт (Studienplatzvormerkung) эсвэл их/дээд сургуулийн элсэлтийн шалгатанд бүртгүүлсэн баримт (Bewerberbestätigung) эсвэл UNI ASSIST-аас өгсөн эцэслэсэн шийдвэр эсвэл Коллежийн элсэлтийн шалгалтанд орох урилга

Хэлний мэдлэгийг батлах баримт: Das Deutsche Sprachdiplom (DSD) эсвэл ALTE (Association of Language Testers in Europe) стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байгууллагаас олгосон **сертификат**

Ерөнхий боловсролын гэрчилгээ, их дээд сургууль төгссөн бол диплом болон дүнгийн хавсралт

Та одоогоор ажил эрхэлж байгаа бол ажлын газрын тодорхойлолт

Германд дээд боловсрол эзэмших болсон шалтгаан, өөрийн сонгосон мэргэжлийн тухай, хэтийн зорилгын талаарх бичмэл тайлбар захидал (**Motivationsschreiben**) герман хэл дээрх орчуулгын хамт

Өнөөг хүртэл эзэмшсэн боловсрол, мэргэжил болон эрхэлж байсан ажил, хөдөлмөрийн талаарх бүрэн гүйцэд бичсэн, **хүснэгтчилсэн намтар** герман хэл дээрх орчуулгын хамт

9. Сурах үеийн санхүүжилт

Их/дээд сургуульд сурах хүн **нэг сарын 992** евроны санхүүгийн баталгааг нэг жилээр буюу **11904 еврог байршуулсан** баримтыг визийн мэдүүлэгт хамт өгнө.

Их/дээд сургуульд элсэн орох өргөдөл гаргасан виз мэдүүлэгч (Studienbewerber) нэг сарын 1091 еврогоор тооцож ихдээ 9 сар Германд оршин суух боломжтой учраас санхүүгийн баталгаа болох 9819 евро байршуулсан баримтаа визийн мэдүүлэгт хамт өгнө.

Санхүүгийн баталгааг дараах байдлаар гаргаж болно

Германы ямар нэгэн сан, байгууллагаас тэтгэлэг авсан тухай баримт. Тэтгэлгийн хэмжээ дээр дурьдсан хэмжээнд хүрэхгүй байгаа тохиолдолд зөрүүг өөр санхүүжилтийн аргаар нэхэн байршуулах ёстой.

Германы Оршин суух тухай хуулийн 66–68 зүйлд заасны дагуу албан ёсны батлан даалтын маягт (Verpflichtungserklärung). Гуравдагч этгээдээр гаргуулж болох энэ батлан даалтанд Германд оршин суух зорилгыг тодорхой бичсэн байх ёстой. Дэлгэрэнгүй мэдээллийг батлан даагч өөрийн хотын Гадаадын иргэн харьяатын газраас, гадаадад амьдардаг бол Герман улсын төлөөлөгчийн газраас авах хэрэгтэй.

Германы аль нэг банкинд хязгаартай ашиглах данс (Sperrkonto) нээлгэж сар болгон амьжиргаанд хүрэхүйц мөнгөн дүнг авах боломжтой байх ёстой бөгөөд эхний нэг жилийн амьжиргааны зардлаа байршуулна. Хязгаартай данс нээхэд зуучилдаг байгууллагуудаас Та өөрөө сонгоно. Дэлгэрэнгүй мэдээллийг Германы Элчин сайдын яамны цахим хуудаснаас авах боломжтой.

Хувийн, төлбөртэй дээд сургуульд сурах бол дараах баримт бичгүүдийг нэмэлтээр өгнө:

Нэг хичээлийн жилийн төлбөр болон төлөлтийн хуваарь



- Төлбөр (урьдчилгаа) төлсөн баримт
 Үлдэгдэл төлбөрөө барагдуулах хэмжээний мөнгө байршуулсан Монгол улсын аль нэг банкны дансны тодорхойлолт

10. Эрүүл мэндийн даатгал

Герман улсад нэвтрэн орох өдрөөс эхлэх хүчинтэй эрүүл мэндийн даатгалыг визийн мэдүүлгэнд өгнө. Оюутны хувьд Германы төрийн эрүүл мэндийн даатгалд (gesetzliche Krankenversicherung) хамрагдах хүсэлтэй байгаа бол энэхүү даатгал нь сургуульдаа элсэн орж Германд оршин суух хаягийн бүртгэл хийлгэсний дараа хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ гэдгийг анхаарах нь зүйтэй. Ийм учраас Герман улс руу нэвтрэн орохдоо хувийн даатгалын компаниар (Incoming- Krankenversicherung) нийт шенгений нутаг дэвсгэрт хүчинтэй, нөхөн төлбөрийн хэмжээ 30000€, 90 хоногийн даатгал хийлгэж визийн мэдүүлэгт хамт өгнө.

11. Визийн хураамж

Визийн мэдүүлэг өгөхөд хураамж төлнө. Энэхүү хураамжийг визийн мэдүүлгийг татгалзсан, өөрийн хүсэлтээр визийн мэдүүлгээ татаж авсан аль ч тохиолдолд буцаан олгохгүй. 75,00 евроны хураамжийг Монгол төгрөгөөр төлөх бөгөөд үүн дээр VFS Global-ын цахим хуудаснаа тавигдсан үйлчилгээний хураамж нэмэгдэнэ. Германы аль нэг олон нийтийн байгууллагаас олгосон тэтгэлэгтэй сурах бол визийн хураамжаас чөлөөлөгдөх ба VFS GLOBAL-ын хураамжийг төлнө.

12. Анхаарах зүйл

Буруу мэдээллийн эх сурвалжаас болж цаг хугацаа, мөнгөө дэмий бүү үрээрэй. Виз мэдүүлэх тухай бүх мэдээллийг Та манай Элчин сайдын яамны цахим хуудаснаас авах боломжтой:

www.ulanbator.diplo.de

Таны хайсан мэдээлэл манай цахим хуудаснаа байхгүй бол ЭСЯ-руу цахим шуудангаар асуултаа илгээж болно. Гуравдагч этгээд, зүүчлагч байгууллага, аялал зохион байгуулдаг, визийн зөвлөгөө өгдөг гэх хувь хүн, байгууллагууд, цахим хуудсууд буруу мэдээлэл түгээх нь олонтаа тохиолддог. Ийм мэдээллийн дагуу визийн мэдүүлэгт бэлдэх, визээ мэдүүлэх нь цаг хугацаа болон мөнгөө алдах магадлалтай. Ялангуяа хэн нэгэн төлбөртэй үйлчилгээ санал болгож байгаа бол Та сэрэмжлэхэд илүүдэхгүй.

Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, визийн мэдүүлгийн маягтыг үнэ төлбөргүйгээр тус ЭСЯ-ны цахим хуудаснаас татаж авах боломжтой.

Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэмэгц Та паспортаа авах боломжтой. VFS Global төвөөр дамжуулан визээ мэдүүлсэн бол тус байгууллага Танд мэдэгдэх болно.

Зарчмын хувьд Та паспортаа өөрийн биеэр ирж авах ёстой. Өөрөө биечлэн авах боломжгүй тохиолдолд паспортаа итгэмжлэгдсэн бие төлөөлөгчөөр авахуулж болно.

Танд олгосон визийн наалт дээрх бичвэрүүд зөв байвал таны аялалд саад болох зүйл ЭСЯ-ны зүгээс байхгүй. Визийн наалт дээрх эцэг/эхийн ба өөрийн нэр, гадаад паспортын дугаар болон таны цээж зураг мөн эсэхийг шалгах хэрэгтэй. Виз нь эхлэх дуусах хугацаатай мөн Герман оронд байх хоногийн тоо, хилээр нэвтрэх тоо бичигдсэн байдаг. Ямар нэгэн тоо, хугацаа, нэр буруу байх аваас нэн даруй ЭСЯ-ны ажилтанд мэдэгдээрэй. Шалгаж нягтлаагүйгээс үүдэх хожмын үр дагавар, ямар нэгэн санхүүгийн хохирлыг ЭСЯ хариуцахгүй.

13. Танилцуулга

Доорх зааварчилгаатай миний бие танилцсан болно:



- Хуурамч баримт бичиг болон худал мэдүүлэг өгөх нь визийн мэдүүлгийг татгалзах гарцаагүй шалтгаан бөгөөд Герман руу нэвтрэх хориг цаашлаад бусад шенгений орнууд руу нэвтрэх хориг тавигдаж болзошгүй.
- Энэхүү санамж бичгийг миний бие уншиж танилцсан бөгөөд утга агуулгыг ойлгож буйгаа илэрхийлж гарын үсгээ зурсан болно.
- Тус Элчин сайдын яам надтай цахим шуудангаар харилцаж (E-Mail) болно гэдгийг зөвшөөрч гарын үсгээ зурсан болно.
- Танд хамааралтай бол: миний визийн мэдүүлэг бүрэн гүйцэд биш гэдгийг надад анхааруулж хэлсэн. Бүрэн гүйцэд болоогүй визийн мэдүүлэг өгөх нь татгалзсан шийдвэрт хүргэдэг гэдгийг миний бие мэдэж байгаа хэдий ч өөрийн визийн мэдүүлгээ өгөхөөр шийдсэн болно.

Улаанбаатар хот, огноо
үсгээр бичсэн овог нэр, гарын үсэг

дармал